

Х-1, Д-1, ХН-119, НУ-1

Тушаав. Тушаах учир алба татварын хэлтсийн өргөсөн нь мөнөөхөн аж ахуйн явдлын яамнаас тушаасан 589 тоот бичигт тушаав. Тушаах учир худалдаа үйлдвэрийг эрхлэх хэлтсийн өргөсөн нь: Саяхан манай яамнаас олон албаны ба энгийн газруудад цахилгаан гэрэл хэрэгсүүлэх тухайн дүрэм долоон зүйлийг төлөвлөн зохих газраа явуулжээ. Эдүгээ эдийн засгийн зөвлөлөөс тус газрын нэгдүгээр зүйлд хэлэлцээд эл дүрмийн дотроос хоёрдугаар, зургаадугаар зүйлийг хасаж бусдыг бага сага залруулан засамжилж, батлан аж ахуйн яамнаа явуулж, гүйцэтгүүлэхээр тогтсон зэрэг учрыг гаргаж, уг дүрмийг хөрвүүлэн 39 тоот хуудсанд дагалдуулан илгээн иржээ. Иймийн тул уг дүрмийг бичгийн хойно сийрүүлэн бичиж, үүнийг зохих олон газруудад хуваан явуулан тушаагаад өөр өөрийн харьяат зохих газруудад зарлан тушаах зэргээр дагаж шийтгүүлье хэмээжээ. Иймийн тул уг дүрэм бичгийн хойно хэвээр сийрүүлэн, үүнийг харьяат арван таван хороодын захирал, орос, хятад худалдааны дарга нарт хуваан тушаан явуулаад хүрмэгц хянан үзэж, улмаар тус бүрийн харьяалах газруудад зарлан тушааж дагаж шийтгүүлье хэмээмүй хэмээн өргөжээ. Үүний тул илгээв.

Арван тавдугаарын оны зургаан сарын дөрвөн, дугаар 229

Сийрүүлэн бичиг нь

ЦАХИЛГААН ХЭРЭГЛЭГЧДИЙН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Олон албаны газруудад хэрэгсүүлэх ламп /ланпуг/ гэрлийн тоог уг төсөвлөсөн дансны төсөвлөсөн ёсоор хэрэгсүүлэхээс гадна албан хаагчид буюу энгийн ард ба пүүсэд гэрэл хэрэгсэхүй нь болбоос цахилгаан гэрлийн хорооноо мэдүүлж гүйцэтгэвээс зохимуй.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Гэрлийн үнэ мөнгийг албаны газар буюу албан хаагчид ба энгийн газрууд хэмээн ялгаварлахгүй сар бүрийн эцэст нэгэн адил хураалгаваас зохимуй.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Гэрэл хэрэгсэгчдийн ламп бүрт ломбо хэмээх тэмдэг тавьж сүйтгэлийг хурааваас зохимуй. Хэрвээ ламп гэрэл шалган байцаах тухайд тэмдэггүй ламп байваас уул хурааваас зохих мөнгөний дээр арван хувь нэмэн торгомуй. Торгож хураасан мөнгөний зуун хувийн гурван хувийг байцаан гаргасан этгээдэд олгуулсугай.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Цахилгаан гэрлийн хорооноос зөвшөөрөлгүй өөрийн дур зоргоор явуулах утаснаас залгаж гэрэл хэрэгсэгчид гарах аваас тэр зүйлийн бүх хэрэгслийг хураан авахаас гадна ламп бүрийн арван төгрөгөөс хорин таван төгрөг хүртэл торгож шийтгэмүй.

ТАВДУГААР ЗҮЙЛ. Харьяат цахилгаан гэрлийн хорооноос албан ба энгийн газруудад тавьсан гэрлийг сар тутам нэгэн удаа байцаан үзүүлбээс зохимуй.